

ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ДАШБАЛБАР СУМЫН ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН,  
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

**Аудитын код:** ДОА-2022/06/НА/СТА-ТТЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Чойбалсан хот 2022 он</p>	<p>Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: И.Сэмжидмаа Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Нармандах Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

1. Аудитын санал дүгнэлт .....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
3. Аудитын тайлан .....	7
3.1 Ерөнхий зүйл .....	7
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	7
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	7
3.4 Материаллаг байдал .....	8
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	8
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	8
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	9
3.8 Аудитын гол асуудал .....	10
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	10
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	10
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	10
4. Аудитын илрүүлэлт .....	10
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	11

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аудитын газар
НА	Нотлох аудит
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СХС	Сум хөгжүүлэх сан
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч

## 1.Хараат бус аудиторын дүгнэлт



Г ДАШБАЛБАР СУМЫН ЗАСАГ ДАРГА  
Ж.ЁНДОНЖАМЦ ТАНАА 7

**ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг  
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2022.02.25 № 389

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ 7

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Дашбалбар сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дашбалбар сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.БОЛОРТУУЛ



011020209

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,924,641.51</b>	<b>1,876,088.28</b>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	187,153.66	701,502.57
33	АВЛАГА	259,963.98	559,222.45
35	БАРАА МАТЕРИАЛ	1,477,523.87	612,613.26
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>6,248,964.28</b>	<b>10,047,804.07</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>6,248,964.28</b>	<b>10,047,804.07</b>
39300	Биет бус хөрөнгө	123,095.21	141,104.60
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>8,173,605.79</b>	<b>11,923,892.36</b>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	78.67
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	78.67
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>8,173,605.79</b>	<b>11,923,813.68</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>8,173,605.79</b>	<b>11,923,813.68</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,605,979.96	2,057,850.11
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>5,167,597.06</b>	<b>8,215,079.65</b>
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,400,028.77	1,650,883.93
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>8,173,605.79</b>	<b>11,923,892.36</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>8,544,897.74</b>	<b>9,452,700.71</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>170,447.67</b>	<b>307,353.07</b>
110	Орлогын албан татвар	83,440.69	67,380.99
113	Хөрөнгийн албан татвар	3,200.00	4,214.50
118	Бусад татвар, төлбөр, хураамж	83,806.98	235,757.58
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>3,655,186.44</b>	<b>5,370,391.31</b>
120	Нийтлэг татварын бус орлого	3,337,662.44	5,047,817.31
122	Тусламжийн орлого	317,524.00	322,574.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>4,719,263.63</b>	<b>3,774,848.34</b>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,353,489.60	1,940,724.10
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	344,319.14	538,554.33
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	3,021,454.89	3,465,290.58
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>4,979,423.50</b>	<b>3,900,555.39</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>4,979,423.50</b>	<b>3,900,555.39</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,837,506.51</b>	<b>3,613,317.09</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,405,741.51	1,843,125.98
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	176,423.51	253,337.49
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	81,540.71	115,591.83
2104	Хангамж, бараа материалын зардал	100,852.68	133,129.58
2106	Нормативт зардал	61,314.01	471,380.97
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,064.57	32,369.49
2107	Томилолт, зочны зардал	3,326.00	7,774.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	37,002.87	74,837.64
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	960,240.64	681,770.11
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,141,916.99</b>	<b>287,238.31</b>
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>3,565,474.24</b>	<b>5,552,145.31</b>
<b>IV</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	<b>0.00</b>	<b>23,609.00</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,474,086.06</b>	<b>3,017,029.96</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>1,091,388.18</b>	<b>2,558,724.36</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	1,605,979.96	1,400,028.77	4,076,208.88	7,082,217.61
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,605,979.96	1,400,028.77	4,076,208.88	7,082,217.61
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	1,091,388.18	1,091,388.18
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,605,979.96	1,400,028.77	5,167,597.06	8,173,605.79
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,605,979.96	1,400,028.77	5,167,597.06	8,173,605.79
13	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	451,870.15	250,855.16	488,758.23	1,191,483.54
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,057,850.11	1,650,883.93	5,656,355.29	9,365,089.33
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	2,558,724.36	2,558,724.36
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	2,057,850.11	1,650,883.93	8,215,079.65	11,923,813.68

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>6,245,782.96</b>	<b>5,858,991.37</b>
11	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>170,447.67</b>	<b>307,353.07</b>
110	Орлогын албан татвар	83,440.69	67,380.99
113	Хөрөнгийн албан татвар	3,200.00	138,453.20
118	Бусад татвар, төлбөр, хураамж	83,806.98	101,518.88
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	4,068.50	4,524.39
1181	Газрын төлбөр	24,151.48	54,158.04
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	55,587.00	42,836.45
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,356,071.66</b>	<b>1,911,925.87</b>
120	Нийтлэг татварын бус орлого	1,038,547.66	1,589,401.87
122	Тусламжийн орлого	317,524.00	322,524.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>4,719,263.63</b>	<b>3,639,712.44</b>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,353,489.60	1,940,724.10
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	344,319.14	403,418.43
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	3,021,454.89	1,283,211.10
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	0.00	12,358.81
II	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>4,405,205.03</b>	<b>3,107,469.91</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>4,405,205.03</b>	<b>3,107,469.91</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,260,918.04</b>	<b>2,826,231.11</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,415,200.99	1,880,395.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	181,300.52	253,339.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	88,134.18	123,603.33
2104	Хангамж, бараа материалын зардал	67,009.39	108,444.62
2105	Нормативт зардал	62,892.83	276,631.90
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,730.01	36,635.29
2107	Томилот, зочны зардал	3,326.00	7,774.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,086.09	28,879.78
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	426,238.03	110,527.29
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,144,286.99</b>	<b>281,238.80</b>
III	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>1,840,577.94</b>	<b>2,751,521.46</b>
V	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>2,126,052.80</b>	<b>2,091,172.56</b>
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>2,126,052.80</b>	<b>2,091,172.56</b>
VI	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-2,126,052.80</b>	<b>-2,091,172.56</b>
VII	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	<b>-91,700.00</b>	<b>-146,000.00</b>
23	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>91,700.00</b>	<b>146,000.00</b>
VIII	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>-377,174.86</b>	<b>514,348.91</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	564,328.52	187,153.66
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	187,153.66	701,502.57

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>5,734,366.20</b>	<b>4,810,584.18</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,998,688.20</b>	<b>2,628,613.72</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,956,801.40</b>	<b>2,587,697.37</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,959,777.30	1,840,825.66
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	256,290.40	244,263.38
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	127,927.30	115,467.25
2104	Хангамж, бараа материалын зардал	98,351.80	93,248.11
2105	Нормативт зардал	149,665.10	115,529.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	49,520.00	47,687.11
2107	Томилолт, зочны зардал	12,733.90	6,638.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	24,248.20	21,901.73
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	278,287.40	102,136.63
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>41,886.80</b>	<b>40,916.35</b>
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>2,475,229.20</b>	<b>2,035,970.46</b>
23	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>260,448.80</b>	<b>146,000.00</b>
III	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>5,734,366.20</b>	<b>5,138,024.54</b>
31	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,940,724.10</b>	<b>1,940,724.10</b>
32	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>3,032,605.40</b>	<b>2,711,823.57</b>
33	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>12,206.60</b>	<b>12,358.81</b>
35	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>426,306.10</b>	<b>150,594.07</b>
36	<b>ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ</b>	<b>322,524.00</b>	<b>322,524.00</b>
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл□	0.00	77,892.81
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл□	0.00	195,895.49

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>403,238.43</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>403,238.43</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>240,659.22</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	14,322.37
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,806.95
2104	Хангамж, бараа материалын зардал	12,442.87
2105	Нормативт зардал	161,102.40
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	36,110.18
2107	Томилолт, зочны зардал	1,052.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,987.80
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,834.66
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>162,579.21</b>
I	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>403,418.43</b>
III	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	<b>180.00</b>
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	180.00

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дашбалбар сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Нармандах гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер И.Сэмжидмаа, газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Болортуул нар тус тус хэрэгжүүлсэн.

Дашбалбар сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 3 дугаар сарын 03-ны өдрийн 1/107 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл нь харьяалах нутаг дэвсгэрийнх нь эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудлаар төрийн эрх бүхий байгууллагаас батлах төсөл, хөтөлбөрт санал өгөх, тэдгээрийн хэрэгжилтийг зохион байгуулах, нутгийн захиргааны байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангах, иргэдэд төрийн үйлчилгээг хүргэх.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллага нь хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын нэгжгүй бөгөөд хяналтыг аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү, хяналт аудитын алба, Санхүү, төрийн сангийн хэлтэс хэрэгжүүлэн ажилладаг байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү, хяналт аудитын алба нь 2021 онд Орон нутгийн хөрөнгө оруулалт болон ОНХС, СХС-гийн 2020-2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийсэн байна.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дашбалбар сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төлөвлөгөөний нийт зардлын 3,908.0 сая төгрөгөөс 1 хувиар тооцон 39.1 сая төгрөгөөр гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 27.4 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 701.5 сая төгрөг болж өмнөх оноос 514.3 сая төгрөгөөр өссөн байна.

Авлага дансны үлдэгдэл 559.1 сая төгрөг болж 299.1 сая төгрөгөөр өссөн нь гүйцэтгэлээр эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн, Байгаль хамгаалах нөхөн сэргээлтийн шүүхийн шийдвэрийн дагуу Сангийн яамнаас авах авлага, төсвийн байгууллагын цалингаас суутган тооцсон ХХОАТ-ыг илүү шилжүүлсэнтэй үүссэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 612.6 сая төгрөг болж 864.9 сая төгрөгөөр буурсан нь өмнөх онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж буй Буриадын өв соёлын музейн барилга, сургуулийн хөл бөмбөгийн талбайн, цахилгаан дамжуулах агаарын шугамын ажлыг дуусаагүй үйлдвэрлэл дансанд бүртгэлтэй байсныг үндсэн хөрөнгийн данс руу шилжүүлэн бүртгэсэнтэй холбоотой байна. Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 10,047.8 сая төгрөг болж 3,798.8 сая төгрөгөөр өссөн нь хөрөнгө оруулалт хийгдсэн, Сум дундын эмнэлэг нь орон нутагт шилжиж ирсэнтэй холбоотой байна.

Биет бус хөрөнгийн дансны үлдэгдэл 141.1 сая төгрөг байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 0.1 сая төгрөг нь ХХОАТ-ын өглөг байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 11,923.7 сая төгрөг болж 3,750.1 сая төгрөгөөр өссөн нь хөрөнгө нэмэгдсэн, Сум дундын эмнэлэг нь орон нутагт шилжиж ирсэнтэй холбоотой байна.

Дашбалбар сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 907.7 сая төгрөгөөр буюу 10.6 хувиар өссөн байна.

Нийт зардал өмнөх оноос 944.5 сая төгрөгөөр буюу 21.6 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа үйлчилгээний бусад болон үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Дашбалбар сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 5,734.4 сая төгрөгөөр, нийт зарлагыг 5,734.4 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 5,734.4 сая төгрөгийн төсөв баталснаас орон нутгийн төсвөөс 3,032.7 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээс 1,940.7 сая төгрөг, нийгмийн даатгалын сангийн төсвөөс 12.2 сая төгрөг, үйл ажиллагааны орлогоос 426.3 сая төгрөг, хандив тусламжаас 322.5 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс орон нутгийн төсвөөс 2,711.8 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээс 1,940.7 сая төгрөг, нийгмийн даатгалын сангийн төсвөөс 12.2 сая төгрөг, үйл ажиллагааны орлогоос 150.6 сая төгрөг, хандив тусламжаас 322.5 сая төгрөгөөр орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд бүрэн зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 4,810.6 сая төгрөг буюу 83.9 хувийн гүйцэтгэлтэй байна.

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуульд зааснаар 2021 онд 1,749.4 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 1,703.5 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөний биелэлт 97.4 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 336.9 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 40.6 сая, хандив тусламжийн 25.8 сая, нийт 403.4 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлд 16.1 сая, хангамж, бараа материалын зардалд 12.4 сая, норматив зардалд 161.1 сая, эд хогшил, урсгал засварын зардалд 36.1 сая, дотоод албан томилолт 1.1 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж 5.0 сая, бусад зардалд 171.4 сая, нийт 403.2 сая төгрөгийг зарцуулан 0.2 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

Бараа материалын дансанд бүртгэлтэй малын тооллого хийсэн бүртгэл, тайлан байхгүй, зөвхөн А дансыг үндэслэн бүртгэл тайланд тусгасан байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ, үйл явдал гараагүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант хугацаанд оруулбал зохих 154 мэдээллээс 3 мэдээлэл хугацаа хоцроон мэдээлсэнд шилэн дансны тухай хуульд заасан хугацаанд мэдээллийг байршуулж байх зөвлөмж өгөв.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 959.8 сая төгрөгийн 1 албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлсэн байна.

#### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц чухал асуудал гараагүй.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 473.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 4.8 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 468.3 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлсэн.

### **4.1 Залруулсан алдаа**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай залруулах бичилт хийгдээгүй болно.

## 4.2 Төлбөрийн акт

Тус сумын Ерөнхий боловсролын сургууль нь 3.2 сая төгрөгийн, хүүхдийн цэцэрлэг нь 1.6 сая төгрөгийн ХХОАТ-ыг илүү шилжүүлэн санхүүгийн тайлан баланс-д авлагаар тусгаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ давхар бичилтийн аргаар хөтөлнө”, 14.4-т “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2-т “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв, толилуулга батламж, мэдэгдлүүдийг хангахгүй байна.

## 4.3 Албан шаардлага

1. Санхүүгийн тайланд тусгагдсан авлагын 6.2 хувь нь СХС-гаас олгосон зээл, зээлийн хүүгийн 34.7 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн авлага байна. Үүнээс 27.5 сая төгрөгийн авлага нь шүүхийн шийдвэртэй, 7.2 сая төгрөгийг барагдуулах зохион байгуулалтын ажил хийгдээгүй байна. Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих, журам”-ын 4.7 -д “Иргэн, хуулийн этгээд авсан зээл, зээлийн хүүг гэрээнд заасан хугацаанд сангийн дансанд буцаан төлнө”, 5.2-т “Сангийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг сумын Засаг дарга хариуцан арилгана” гэсэн заалттай нийцэхгүй байна.

2. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 184.4 сая төгрөгийн 14 ажил, ОНХС-гийн хөрөнгөөр 2,290,8 сая төгрөгийн 9 төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээр батлагдсан байна. Үүнээс хөрөнгө оруулалтын "сумын төсвийн 1 км сайжруулсан замын ажил"-ын 15.0 сая төгрөгийн 1, ОНХС-гийн "Буриадын өв соёлын музейн барилга"-ын 1,008.7 сая төгрөгийн 1 ажил тус тус дутуу, "гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардал, сургалт сурталчилгааны зардал"-ын 20.0 сая төгрөгийн 1 арга хэмжээ огт хийгдээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2-т “Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ”, 41.2.7-д “хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Дээрх шилэн дансны тухай хуульд заасан хугацаанд мэдээллийг байршуулж байх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2022 оны 8 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Дашбалбар сумын ТТЗ	4	473.1	-	-	1	4.8	2	468.3	1	-